



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ТӨВ ЭМНЭЛЭГ**

16052 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
2-р хороолол, П.Жасрайн гудамж 6,
Утас: 24-49-50, Факс: 24-49-76
E-mail: tsd@ubtz.mn

2024.04.11 № 39/228
танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх нь:

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын Төв эмнэлгээс 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр “Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурууд худалдан авах” УБТЗТЭ/20240102001 дугаартай тендерийг зарласан.

Уг тендер шалгаруулалтын тендерийн баримт бичигтэй холбогдох гомдол гарсан тухай Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/413 дугаартай албан бичгээр түдгэлзүүлсэн.

Улмаар тус газраас 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/540 дугаартай албан бичгээр гомдлыг хянаж, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичгийн Багц-11-т холбогдох өөрчлөлт оруулан тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулах талаар шийдвэрлэсэн.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 7.2-т заасны дагуу тариур 1 гр, тариур 3 гр, тариур 5 гр, тариур 10 гр, тариур 20 гр-ыг багцлан тендер шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цаг хүртэл үргэлжлүүлэн хүлээн авч, тус өдрийн 10 цаг 30 минутад www.tender.gov.mn цахим системээр нээх болсныг үүгээр мэдэгдэж байна.

СУРГАЛТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ГАДААД
ХАРИЛЦАА ЭРХЭЛСЭН
ОРЛОГЧ ДАРГА



Д.БАТ-УНДРАХ

1639240073